

АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХИЙСЭН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2019.12.13

Нийтлэг үндэслэл

Сангийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 119 дүгээр тушаалаар Аудитын хуулийн этгээдэд чанарын хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, шалгалт хийх хуулийн этгээдийн нэрсийн хамтаар батлуулан, хяналт шалгалтын ажлыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн хооронд, 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хооронд тус тус хийж гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтыг Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын хуулийн этгээд чанарын хяналт хийх журам”-ын дагуу хийсэн болно.

Шалгалтыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн төлөөлөл болон Нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн нараас бүрдсэн нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй хийлээ.

Хяналт, шалгалтын дүгнэлт:

Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ын дагуу аудитын хуулийн этгээдийн Хууулийн түвшинд, байгууллагын түвшинд, ажлын баримтын түвшинд тус тус үнэлгээ өгсөн болно.

- **Хангалттай буюу 75%-иас дээш үнэлгээ** авсан “Юнистар Аудит” ХХК, “Сүлд Аудит” ХХК, “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК, “Баянташаагийн эх Аудит” ХХК, “Гроут финанс Аудит” ХХК, “Ди эй би жи Аудит” ХХК, “Их наяд Аудит” ХХК, “Мэжик консалтинг Аудит” ХХК, “Нью эстимэйтор Аудит” ХХК, “Севилия Аудит” ХХК, “Шонхор үнэлгээ Аудит” ХХК, “Авера Аудит” ХХК, “Интер Аудит” ХХК, “Нью проспект Аудит” ХХК, “Цэгцтөв богд Аудит” ХХК, “БДО Аудит” ХХК нарын 16 хуулийн этгээд;
- **Сайжруулах шаардлагатай буюу 50%-75%-ийн үнэлгээ** авсан “Бодьтусгал Аудит” ХХК, “Голден пэйж Аудит” ХХК, “Бизкон Аудит” ХХК, “Глобал капитал Аудит” ХХК, “Ниямазон Аудит” ХХК, “Реланэнс секьюритиз Аудит” ХХК, “Энур Аудит” ХХК, “Юникапитал Аудит” ХХК нарын 8 хуулийн этгээдэд зөрчил арилгах талаар ажлын төлөвлөгөө гаргаж ирүүлэх тухай хугацаатай албан шаардлагыг Сангийн дэд сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 7/8686, 7/8687 албан тоотоор хүргүүлсэн;

- Сангийн сайдын 2019 оны 285 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартын дагуу ажлын баримт бүрдүүлээгүй, **Хангалтгүй буюу 50%-иас доош үнэлгээ** авсан “Файнаншил про Аудит” ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон;
- Сангийн сайдын 2019 оны 286 дугаар тушаалаар **Хяналт шалгалтын явцад тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах хүсэлтээ гаргасан** Айд валью Аудит ХХК, Батламж Аудит ХХК нарын 2 хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус хүчингүй болсон;
- Сангийн сайдын 2019 оны 285 дугаар тушаалаар **Аудитын тухай хуулийн нөхцөл шаардлагыг нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй нь тогтоогдсон** “Хонгорын үр сад Аудит” ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн;

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗАР